



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН  
ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Дархан-Уул  
2026

## Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй

Холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн гүйцэтгэлийг хяналтанд авсан зүйл, заалттай харьцуулан хяналт-шинжилгээ хийх, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, үүрэг болгосон зүйл, заалтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд зорилго оршино.

Хяналтанд авсан Монгол Улсын хууль, УИХ-ын тогтоол, УИХ-ын Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгаврын явцын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2025 оны 183 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журам”-ыг удирдлага болгон Үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагын систем “Хяналт-шинжилгээ, үнэлгээ” дашбоардын аргачлалын дагуу гүйцэтгэлээ.

“Хууль тогтоомж, тогтоол шийдвэр” цэсэд байршсан 121 шийдвэрийн 236 заалт, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хариуцсан мэргэжилтний нэгтгэн, Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст ирүүлсэн тайлан, арга зүйн зөвлөгөөний хүрээнд сайжруулсан нэмэлт тоон үзүүлэлт, мэдээлэлд үндэслэн гүйцэтгэлээ.

Хяналтанд авсан шийдвэрийн зүйл, заалтын явцын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ 5 шатлалт аргачлалаар тооцлоо.

Үүнд:

- Хэрэгжсэн буюу 100%
- Хэрэгжих шатанд буюу 50% /ахиц гарсан, тодорхой үр дүнд хүрсэн, удаашралтай/эрчимжүүлэх шаардлагатай/
- Хэрэгжээгүй буюу 0% /зохион байгуулалтаас, санхүү хөрөнгө оруулалтаас/
- Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй буюу ХБ
- Хэрэгжих боломжгүй /хугацаа тодорхойгүй, чиг үүрэг тодорхойгүй, зардал санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй, үйл ажиллагаа зорилго тодорхойгүй, хэмжигдэхүйц биш/

**Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн**

2026 оны эхний хагас жилийн байдлаар аймгийн ЗДТГазрыг хяналтанд авч, хэрэгжүүлэхийг үүрэг болгосон:

- ✓ Монгол Улсын 1 хуулийн 1 заалт,
- ✓ УИХ-ын 11 тогтоолын 19 заалт,
- ✓ УИХ-ын байнгын хорооны 18 тогтоолын 38 заалт,
- ✓ Монгол Улсын Ерөнхийлөгчийн 9 зарлигийн 14 заалт,
- ✓ Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 10 зөвлөмжийн 27 заалт,
- ✓ Засгийн газрын 35 тогтоолын 55 заалт,
- ✓ Ерөнхий Сайдын 2 захирамжийн 2 заалт,
- ✓ Засгийн газрын хуралдааны 32 тэмдэглэлийн 69 заалт,
- ✓ Засгийн газрын 3 албан даалгаврын 11 заалт, нийт 121 шийдвэрийн 236 заалтыг хяналтанд авлаа.

Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн цахим сан “Хууль тогтоомж, тогтоол шийдвэр”- цэсэд 2026 оны эхний хагас жилд 5 удаа байршсан (давхардсан тоогоор) 460 заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, цахим санд **хугацаанд нь** байршуулан, баталгаажууллаа. Хүснэгт 1-с дэлгэрэнгүйг харна уу.

№	Заалтын тоо	Баталгаажуулсан хугацаа/ баталгаажуулах хугацаа		Хэрэгжилт, /%/
1	3	I/15	I/15	50.0
2	12	III/16	III/16	87.5
3	11	IV/09	IV/10	80.0
4	198	V/01	V/05	58.95
5	236	VI/29	VII/01	88.05
Давхардсан тоогоор 460		Дундаж 72.9%		

Өмнөх оны мөн үеүүдтэй харьцуулахад (2024 онд 696, 2025 онд 588) давхардсан тоогоор заалтын тоо 128-236-аар багассан байна.

2020-2025 оны эхний хагас жилд хяналтад авсан шийдвэрийн болон заалтын тоо, үнэлгээг харуулбал:

Он	Шийдвэрийн тоо	Заалтын тоо	Үнэлгээ
2020 оны	58	109	83.50%
2021 он	67	126	76.67%
2022 он	82	194	64.48%
2023 он	58	146	87.97%
2024 он	128	241	89.43%
2025 он	159	267	85.00%
<b>2026 он</b>	<b>121</b>	<b>236</b>	<b>88.05%</b>
<b>Дундаж</b>	<b>96.1</b>	<b>188</b>	<b>82.15%</b>

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнд биелэлт **88.05 хувь** буюу өмнөх оны мөн үеийн 85.0 хувийн үзүүлэлтээс **3.05 нэгж хувиар өссөн** байна. Энэ нь байгууллагууд хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах үйл ажиллагаагаа тодорхой хэмжээнд сайжруулсан гэж үзэж болохоор байна.

Хяналтанд авсан шийдвэр, заалтын тоог сүүлийн 7 жилийн дундажаар авч үзвэл **96 шийдвэрийн 188** заалт байна. Хүснэгтээс харвал 2020-2023 оны эхний жилүүдэд хяналтад авч хэрэгжүүлсэн заалтын тоо харьцангуй тогтвортой байсан бол 2024, 2025 оны эхний хагас жилийн байдлаар шийдвэр, заалтын тоо нь харьцангуй өндөр байна.

2020-2026 оны эхний хагас жилийн биелэлтийн дундаж 82.15 хувь байгаа бөгөөд **2026 оны үнэлгээ нь дунджаас 5.9 нэгж хувиар өндөр** байна.

**Хэрэгжилтийн ерөнхий дүнг хураангуй байдлаар харуулбал:**

№	Үнэлгээ	Нийт	
1.	<b>Хяналтанд авсан шийдвэрийн тоо</b>	<b>121</b>	
2.	<b>Хяналтанд авсан заалтын тоо</b>	<b>236</b>	
3.	Хэрэгжилт, үүнээс	<b>Хэрэгжсэн буюу 100%</b>	<b>158</b>
		<b>Хэрэгжих шатанд буюу 50.0%</b>	<b>45</b>
		• Ахиц гарсан	11
		• Тодорхой үр дүнд хүрсэн	25
		• Удаашралтай/ эрчимжүүлэх	9
		<b>Хэрэгжээгүй буюу 0%</b>	<b>2</b>
		• Зохион байгуулалтаас	2
		• Санхүү, хөрөнгө оруулалтаас	-
		<b>Хугацаа болоогүй буюу ХБ</b>	<b>20</b>
		<b>Хэрэгжих боломжгүй</b>	<b>11</b>
		• Хугацаа тодорхойгүй	-
		• Чиг үүрэг тодорхойгүй	10
		• Зардал, санхүүгийн эх үүсвэргүй	1
		• Үйл ажиллагаа, зорилго тодорхойгүй	-
• Хэмжигдэхүйц биш	-		
<b>Хэрэгжилтийн дундаж, хувь</b>		<b>88.05%</b>	

2026 оны эхний жилийн байдлаар хяналтад авсан Монгол Улсын хуулийн 1 заалт 100%, УИХ-ын тогтоолын 19 заалт 81.25%, УИХ-ын байнгын хорооны тогтоолын 38 заалтыг 87.50%, Ерөнхийлөгчийн зарлигийн 14 заалт 100%, ҮАБЗөвлөлийн зөвлөмжийн 27 заалт 98.15%, Засгийн газрын тогтоолын 55 заалт 84.52%, Ерөнхий Сайдын захирамжийн 2 заалт 75.0%, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн 69 заалт 85.34%, Засгийн газрын албан даалгаврын 11 заалтын хэрэгжилтийг 90.91%-иар ханган ажилласан байна.

**Холбогдох шийдвэрийн төрөл тус бүрээр хэрэгжилтийн үр дүнг харуулбал:**

№	Шийдвэр		Шийдвэр, төрөл									
	Биелэлтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний явц, үр дүн	Нийт	Монгол Улсын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын Байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгч ийн зарлиг	Засгийн газрын тогтоол	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын албан даалгавар	Ерөнхий Сайдын захирамж	ҮАБ-ын зөвлөлийн зөвлөмж	
1.	Хяналтанд авсан шийдвэрийн тоо	<b>121</b>	1	11	18	9	35	32	3	2	10	
2.	Хяналтанд авсан нийт заалтын тоо	<b>236</b>	1	19	38	14	55	69	11	2	27	
3.	Хасах саналтай	<b>37</b>	-	4	5	3	6	15	-	-	4	
4.	Хэрэгжилт, үүнээс	Хэрэгжсэн 100%	<b>158</b>	1	10	29	12	29	41	9	1	26
		Хэрэгжих шатанд 50%	<b>45</b>	-	6	5	-	13	17	2	1	1
		Хэрэгжээгүй 0%	<b>2</b>	-	-	2	-	-	-	-	-	-
		Хугацаа болоогүй	<b>20</b>	-	2	-	2	11	5	-	-	-
		Хэрэгжих боломжгүй	<b>11</b>	-	1	2	-	2	6	-	-	-
Хэрэгжилтийн дундаж, хувь		<b>88.05%</b>	100%	81.25%	87.50%	100%	84.52%	85.34%	90.91%	75.0%	98.15%	

Хүснэгтээс харвал хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмжийн хэрэгжилт өндөр байгаа бол УИХ-ын тогтоол, Ерөнхий сайдын захирамжийн хэрэгжилт харьцангуй бага байна.

**Хэрэгжээгүй 2 заалтын хувьд** холбогдох заалтын агуулгын хүрээнд хийсэн ажил, үйлчилгээг тайлагнаагүй заалтууд байна. Хүснэгт 2-с дэлгэрэнгүйг харна уу.

Заалт	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Хэрэгжилт
УИХ-ын байнгын хорооны тогтоол				
41	2024 №07 ТББХ — Чиглэл өгөх тухай / УИХ-ын байнгын хорооны тогтоол	1/ Монгол Улсын Их Хурлын D-Parliament болон D-өргөдөл цахим системийг иргэд олон нийтэд тайлбарлан танилцуулж, сурталчлах ажлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаараа дамжуулан тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах	2026 онд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас Улсын Их Хурлын үйл ажиллагааны "D-Parliament" болон "D-өргөдөл" цахим системийг иргэд олон нийтэд танилцуулах, сурталчлах ажлыг зохион байгуулаагүй.	ХГ Хэрэгжүүлэх боломжтой заалт
42		3. Энэ тогтоолын хэрэгжилтийн тайлан мэдээг УИХТГ-т тухай бүр ирүүлж байхыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарт үүрэг болгосугай.	УИХ-ын Тамгын газарт 2025 онд хагас, бүтэн жилээр “Хууль тогтоомж сурталчилах төв”-ийн үйл ажиллагааны тайланг цахимаар хүргүүлсэн. 2026 оны хагас жилийн байдлаар УИХТГ-т тайлан мэдээ хүргүүлээгүй.	ХГ Хэрэгжүүлэх боломжтой заалт

**Хэрэгжих боломжгүй 11 заалтын хувьд** хугацаа тодорхойгүй 10, санхүүгийн эх үүсвэргүй 1 заалт байна. Хүснэгт 3-с дэлгэрэнгүйг харна уу.

Заалт	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Хэрэгжилт
УИХ-ын тогтоол				
17	2024_21 — Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны	2.3 /Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон жил бүрийн	Орон нутгийн захиргааны байгууллагын чиг үүрэгт хамааралгүй.	Хэрэгжих боломжгүй /чиг үүрэг

Дархан-Уул аймгийн ЗДТГ | Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс

	хөтөлбөр батлах тухай / УИХ-ын тогтоол	улсын төсөвт тусган хэрэгжүүлэх;		биш/
УИХ-ын байнгын хорооны тогтоол				
52	2025_04 ЁЗДБХ — Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай / УИХ-ын байнгын хорооны тогтоол	1.3.1 Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, тухайн байгууллагын ЁС зүйн дэд хорооны гишүүдэд олгох урамшууллын асуудлыг шийдвэрлэх, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэн үр дүнг тооцож ажиллах.	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т зааснаар Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно гэх заалтыг үндэслэн Ёс зүйн дэд хорооны гишүүд урамшуулал авах боломжгүй байна.	Хэрэгжих боломжгүй  /санхүү/
58	2025_04 ТББХ — Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай / УИХ-ын байнгын хорооны тогтоол	2. тогтоолын хэрэгжилтийг ханган УИХ-ын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан Байнгын хороонд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газарт	Монгол Улсын Ёс зүйн хорооны ажлын албаны чиг үүрэгт хамаарах заалт	Хэрэгжих боломжгүй  /чиг үүрэг биш/
Засгийн газрын тогтоол				
112	2025_206 — Ой тэмдэглэх тухай / ЗГ-ын тогтоол	3.Ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг шийдвэрлэх, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангахыг Ажлын хэсэг (Н.Учрал)-т, ойг тэмдэглэн өнгөрүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг холбогдох аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, Монгол Улсын Ерөнхий сайд асан Агданбуугийн Амарын мэндэлсний 140 жилийн ойг 2026 онд тэмдэглэн өнгөрүүлэх тухай тогтоол, Тус аймагт үүрэг болгоогүй.	Хэрэгжих боломжгүй  /чиг үүрэг тодорхойгүй/
131	2025_226 — Төрийн жинхэнэ албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай / ЗГ-ын	4. Энэхүү тогтоолыг албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, зайлшгүй шаардлагатайгаас бусад сул орон тоонд албан хаагч нөхөж авахгүй байх, ажлын гүйцэтгэл, үр дүн, бүтээмжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг цахимжуулах зэрэг арга хэмжээ авах замаар 2026 оны батлагдсан	"Төрийн жинхэнэ албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 226 дугаар тогтоол нь <b>орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсвийн байгууллагуудад хамаарахгүй</b> . Орон	Хэрэгжих боломжгүй  /үүрэг чиглэл хамаарахгүй/

Дархан-Уул аймгийн ЗДТГ | Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс

	тогтоол	төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг төсвийн нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	төсвийн нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсвийн байгууллагуудын төрийн захиргааны албан хаагчдын цалингийн хэмжээг нь Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолын дагуу 2026 оны төсөвт батлагдсан хуваариар олгож байна.	
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл				
163	2025_15 — Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 15 дугаар хуралдааны тэмдэглэл	15.13.5.1. Нийслэлийн Шуурхай штабын хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг тогтоосон хугацаанд бүрэн хэрэгжүүлж, Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 7 дугаар хуралдааны тэмдэглэлээр даалгасны дагуу биелэлтийг тухай бүр ERP системээр тайлагнаж ажиллахыг <b>Засгийн газрын гишүүд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч, Эрдэнэс Монгол-д тус тус;</b>	Засгийн газрын гишүүд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч, Эрдэнэс Монгол-д тус тус даалгасан.	Хэрэгжих боломжгүй <b>/чиг үүрэг биш/</b>
168	2025_11 — Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 11 дүгээр хуралдааны тэмдэглэл	нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулахад цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар зөвлөмж, дүгнэлт гаргуулж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад даалгав.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа TENDER.GOV.MN нээлттэй зарлаж байгаа бөгөөд уг системийн талаар цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар зөвлөмж, дүгнэлт гаргуулах талаар тайлант хугацаанд <b>орон нутагт чиглэл ирээгүй байна.</b> <b>Системд энэ заалт 2 удаа буюу жагсаалтын 158,169-д давхцан байршсан байгаа.</b>	Хэрэгжих боломжгүй <b>/чиг үүрэг биш/</b>
169	2025_11 — Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 11 дүгээр хуралдааны тэмдэглэл	нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулахад цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар зөвлөмж, дүгнэлт гаргуулж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад даалгав.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа TENDER.GOV.MN нээлттэй зарлаж байгаа бөгөөд уг системийн талаар цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар зөвлөмж, дүгнэлт гаргуулах талаар тайлант хугацаанд <b>орон нутагт чиглэл ирээгүй байна.</b> <b>Системд энэ заалт 2 удаа буюу жагсаалтын 158,169-д давхцан байршсан байгаа.</b>	Хэрэгжих боломжгүй <b>/чиг үүрэг биш/</b>
186	2025_18 — Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 24-ны өдрийн 18 дугаар	11.2. <b>Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг</b> төлөвлөсөн зорилтот түвшинд хүргэх, эрчимжүүлэх, нөөцийг оновчтой хуваарилах арга хэмжээг шуурхай авч	Тус бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг төрийн захиргааны төв байгууллагууд буюу Яамдууд тайлагнан ажиллалаа. Аймгийн Засаг дарга түүний ЗДТГ-ын чиг үүргийн хүрээнд 2025	Хэрэгжих боломжгүй <b>/чиг үүрэг биш/</b>

	хуралдааны тэмдэглэл	хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд болон аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох төрийн захиргааны байгууллагын дарга нарт даалгав.	онд тайлагнах чиглэл өгөгдөөгүй.	биш/
187	2025_20 — Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 20 дугаар хуралдааны тэмдэглэл	16.4.1. Үүнтэй <b>холбогдуулан 2025 онд багтаан</b> дараах арга хэмжээг авахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга болон мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад даалгав: 1. эрхлэх асуудлын хүрээнд бүрдүүлсэн төрөлжсөн мэдээллийн сангийн мета-өгөгдлийг Төрийн мета-өгөгдлийн нэгдсэн санд бүртгүүлэх;	Төрийн мета өгөгдлийн нэгдсэн сангийн админ эрх олгогдоогүй.	Хэрэгжих боломжгүй  Шийдвэрт заасан хугацаа дууссан
210	2026_06 — Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн 06 дугаар хуралдааны тэмдэглэл	17.4.3. <b>Хойд, хангай, говийн бүсийн</b> хөгжлийг эрчимжүүлэх чиглэлээр баталсан Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүд, аймгийн Засаг дарга нарт даалгав.	Төвийн бүсэд хамаарах аймаг тул хасах	Хэрэгжих боломжгүй  /чиг үүрэг хамаарахгүй/

Засгийн газрын 2025 оны 183 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журам”-ын 6.4-д заасны дагуу:

1. бүрэн хэрэгжсэн,
2. бодит шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй болсон хүчингүй болсон<sup>1</sup>,
3. цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон<sup>2</sup>
4. тухайн шийдвэр хүчингүй болсон
5. шийдвэрт заасан хугацаа дууссан

<sup>1</sup> Төсөв, хөрөнгө, санхүүжилт батлагдаагүй болон шийдвэрт заасан асуудлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагагүй болсон

<sup>2</sup> Үйл явц болоод өнгөрсөн

6. тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан,
7. чиг үүрэгт хамааралгүй дараах 37 заалтыг хяналтаас хасуулах саналыг тайлбарын хамт, цахим санд баталгаажууллаа.

Хасах саналтай 37 заалтаас бүрэн хэрэгжсэн 13, шийдвэр дэх хугацаа дууссан 6, чиг үүрэгт хамааралгүй 17, дахин шийдвэр гарсан 1 заалт байна.

### Гурав. Дүгнэлт

2026 оны эхний хагас жилийн байдлаар Дархан-Уул аймагт хэрэгжүүлэхээр заасан хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт ерөнхийдөө тогтвортой, өмнөх оноос бага зэрэг сайжирсан гэж дүгнэж байна. Гэхдээ тайлангийн чанар, нотлох баримтын бүрдүүлэлт, үр дүнгээ тусгах, хариуцлагыг цаашид сайжруулах шаардлага хэвээр байна.

### Дөрөв. Цаашид хэрэгжүүлэх сургамж, зөвлөмж

#### **Хяналт-шинжилгээний явцад дараах эерэг үр дүн ажиглагдлаа. Үүнд:**

- Хууль тогтоомжийн хэрэгжилтийн нийт түвшин өссөн,
- Цахим системд тайлан байршуулалт, баталгаажуулалт тогтмолжсон,
- ТЗУХэлтэс нэгтгэсэн тайлангаа хугацаанд нь буюу 2026.06.25-ны өдөр багтаан хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст ирүүлсэн,
- Хэрэгжилтийн үнэлгээ өмнөх оны мөн үеэс өссөн,
- Засгийн газрын албан даалгавар, ҮАБЗ-ийн зөвлөмжийн хэрэгжилт өндөр түвшинд хангагдсан байна.

#### **Дараах нийтлэг анхаарах асуудал илэрч байна.**

1. Хэрэгжээгүй 2 заалтын хувьд тайлан ирүүлээгүй.
2. Үйл ажиллагаагаа тайлагнасан боловч үр дүнг нотолсон баримт огт ирүүлээгүй,
4. Биелэлт, тайланг боловсруулах чанар хэлтсүүдийн хооронд харилцан адилгүй,
5. Тайлан ерөнхийдөө үйл ажиллагааг тайлагнасан, үр дүн (эерэг өөрчлөлт)-г тусгасан байдал хангалтгүй байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС